



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/650

Булган сум

Аймгийн аюулгүйн нөөцөд өвс  
хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны 56 дугаар "Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 112/2025 дугаар "Аймгийн аюулгүйн нөөцийн өвс нийлүүлэх гэрээ"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Аймгийн аюулгүйн нөөцөд өвс нийлүүлэх" ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Цаст цант бүтээмж" хоршооноос 9,500 (есөн мянга таван зуу) боодол өвсийг гэрээнд туссан байршилд хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)  
Гишүүд: А.Ганхуяг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)  
М.Лхагваням ("Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн ахлах менежер)  
Л.Наранчимэг ("Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК-ийн менежер)  
Л.Лхамаа (Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)  
Нарийн бичгийн дарга: П.Хишигдаваа (Хүнс хөдөө аж ахуйн газрын Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн)

2. Аймгийн аюулгүйн нөөцөд техникийн тодорхойлолтын шаардлага хангасан өвсийг хүлээн авч, хадгалалт, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг аймгийн "Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй" ОНӨХХК (Э.Мөнх-Очир)-д, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан)-т, хүлээн авах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэж, баримт материал бүрдүүлж ажиллахыг Ажлын хэсэг (О.Ундрах)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010906